

**“МЭРГЭД ГАРАХЫН ОРОН” ТОЛЬД БУЙ
“ТЭЖЭЭХҮЙ УХААНЫ АЙМАГ”-ААС ТҮҮВЭРЛЭСЭН
ЁГТ ҮГЭНД ХИЙСЭН ТАЙЛБАР, ТАЙЛАЛ**

*Хурцаа (Huricha), Ч.Батнайрамдал, Ш.Болд
АШУУИС-ийн МАУОУС*

**EXPLANATION AND INTERPRETATION OF SYNONYMICS FROM
THE “FIELD OF MEDICINE” IN “MERGED GARAHYN ORON”
TIBETAN-MONGOLIAN DICTIONARY**

Huricha, Ch.Batnairamdal, Sh.Bold
International School of Mongolian Medicine, MNUMS

Abstract

Prior to translating Tanjur to Mongolian (1749), “Merged Garahyn Oron” (1742) was written for the translation work to translate terminology of Buddhism from Tibetan to Mongolian and clarify the writing style. The woodblock of “Merged Garahyn Oron” Tibetan-Mongolian dictionary was created in 1924 in Aga Datsan of Buryatia by the initiative of the Institute of Literature and Scripts. The dictionary is a unique masterpiece that significantly influenced the national philosophy, development of scientific disciplines and the great achievements of the Oriental people.

As a result of the research, we compiled 54 complicated and synonymics words from “Field of Medicine” in “Merged Garahyn Oron” dictionary and translated as well as explained each word, thus, providing an opportunity to study traditional medicine with rationale, enrich the traditional medical education materials and to put the interpreted words into research circulation in addition to using in traditional medicine theory and pharmacology. Furthermore, traditional Mongolian medicine has developed a comprehensive medical science system with unique terminology resulting from cognitive development of Mongolians and has been increasingly developing and utilized in day-to-day medical care.

Keywords: Tanjur, Merged Garahyn Oron, synonymics, traditional medicine

Үндэслэл:

Буддын шашинд мэдлэгт тулгуурлан бүтээсэн ухааны их 5 оронд:

1. Дуун ухаан,
2. Учир шалтгааны ухаан,
3. Урлахуй ухаан,
4. Тэжээхүй ухаан,
5. Дотоод ухаан тус тус багтана^{1,2,3}.

Дуун ухаан, учир шалтгааны ухаан хоёр буруу эсэргүүцэгчийг дарах, урлахуй ухаан, тэжээхүй ухаан хоёр бусдыг тэтгэх ухаан юм. Тэжээхүй ухаан буюу анагаах ухааны гол ном Монгол оронд Буддын шашины 2 дахь дэлгэрэлтийн үеэс эхлэн орчуулагдсан Данжуураар дамжин дэлгэрч эхэлжээ.

Ганжуурын тайлбар болох Данжуур (Зарлигийн орчуулга) судар нь 226 боть бөгөөд Энэтхэг, Төвөдийн эрдэмтдийн бичсэн их бага арван ухааны шастирууд, 3427 нэр төрлийн ном зохиолыг багтаасан 107839-н хуудастай их хөлгөн судар юм. Энэхүү Данжуурыг II Жанжаа хутагт Ролбийдорж, Ширээт хутагт Лувсанданбийням тэргүүтэй 200 орчим гүүш төвөд хэлнээс монгол хэлнээ 1741-1742 онд орчуулсан бөгөөд 1742-1749 оны хооронд Бээжинд модон бараар хэвлэсэн олон хүний хамтын бүтээл юм^{4,5,6}. Данжуурыг Монгол хэлнээ орчуулахаас (1749) өмнө “Мэргэд гарахын орон” (1742) хэмээх бүтээлийг уг

орчуулгын ажилд зориулан төвөд хэлээрх Буддизмийн нэр томъёог монгол хэлнээ орчуулах, бичиглэлийн баримжааг нэг мөр шийдэж өгсөн чухал ач холбогдолтой бүтээлийг бичжээ⁷. Мэргэд гарахын орон нэрт төвөд-монгол нэр томъёоны толийн модон барыг Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн санаачлагаар 1924 онд Буриадын Агийн дацанд бүтээлгэжээ⁸. Тус толь бичиг нь гүн ухааны сэтгэлгээ хийгээд шинжлэх ухааны төрөл, салбарын хөгжил дэвшил, дорно дахины ард түмний соёлын гайхамшигт ололтод гүнзгий нөлөө үзүүлсэн хосгүй бүтээл юм. Иймээс энэхүү бүтээлийг судлах явдал хойшлуулшгүй чухал асуудлын нэг болоод байна.

Зорилго

“Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг”-ийн “Тэжээхүй ухааны аймаг”-аас бэрх үг, ёгт нэрийг түүвэрлэн, үг бүрт тайлбар, тайлал хийх.

Судалгааны арга

Герменевтик арга: Герменевтик гэдэг нь тайлбарлах, тодруулах гэсэн грек үгнээс гаралтай бөгөөд сэдвийн өгүүлэмж, зохиогч, нэр томъёо, үгийн утгын тайлал хийх, тайлбарлах, орчуулахын тулд уг арга зүйг боловсруулжээ. Герменевтик нь судалж буй зүйлийнхээ учир зүйг учир шалтгааны холбоогоор тайлбарлан судалдаг. Иймээс бид энэхүү аргыг судалж буй материалын нэр томъёо, үгийн далд утга, давхар санаа, агуулгыг судлан тогтооход ашиглав.

Үр дүн

“Мэргэд гарахын орон нэрт төвөд-монгол нэр томъёоны толь”-ийн “Тэжээхүй ухааны аймаг оршвой” бүлэгт буй зарим ёгт нэрийн утгыг тодруулан тайлбарлах нь онолын болоод практикийн ихээхэн ач холбогдолтой юм. Ер нь уламжлалт анагаах ухааны эмийн түүхий эдийн нэршил, тус эрдэм, хэрэглээг үнэн зөв тодорхойлж танихгүйгээр эм судлал,

эм найрлагын судлал хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, судалгааны ажлын сэдэв, нэр томъёог зөв оновчтой болгох боломжгүй юм.

1.Нэрийн түүвэр

Бид судалгааны ажлын энэхүү зорилтын хүрээнд “Тэжээхүй ухааны аймаг” бүтээлд буй хий өвчнийг, шарын өвчнийг, бадганы өвчнийг, бор өвчнийг, хурмал, хавсарсан өвчнийг, эс шингэснийг, бэтэг өвчнийг анагаах бүлэгт буй 54 ёгт нэрийн түүвэр хийлээ. Үүнд:

1. Бабил
2. Хачын орны Саран итгэл
3. Аварда
4. Гэдийх дарган
5. Өрөөл шог
6. Бишазэ
7. Кали
8. Талд хүрсэн
9. Гашая
10. Зөгөн
11. Сэргэр
12. Лэвган
13. Ашудын
14. Дрэ дрэ хо
15. Цус хатсан зэлдэ
16. Ша ра жа шар
17. Сиввү говзэ
18. Булчирхай врас,
19. Улбарах
20. Амруу
21. Лэвган
22. Эзэт
23. Исгади
24. Сага
25. Маразэ
26. Асо
27. Рагша
28. Бихази
29. Гүмбади
30. Габзали
31. Бидэр

32. Хөрс
33. Манзир
34. Халуун өвс
35. Цагаан сгэ
36. Байванга
37. Марүзэ
38. Халди
39. Хорт бор
40. Үдэгүн хошуу
41. Данрог
42. Шраганда
43. Донга
44. Хулу
45. Дадриг
46. Аглиг
47. Рэгонба
48. Гангачүн
49. Хан төмөр
50. Юүмдүүжин
51. Барын махан цэцэг
52. Гонтог
53. Хар адон
54. Цагаан дадура

2. Түүвэр нэрийн тайлбар, тайлал

Монголын яруу найраг, одон зурхай, анагаах ухаан болон эрдэм ухааны бусад аймгийн ном судрыг уншиж ойлгоход ёгт нэрийг зайлшгүй мэдэх хэрэгтэй.

Энэтхэг, Төвөдийн ухааны бага аймагт багтах ёгт нэрийг Монголчууд зохиол бүтээлдээ өргөн хэрэглэж, толь бичиг зохиож ирсэн баялаг уламжлалтай⁹.

Ёгт нэр гэдэг нь аливаа юмс үзэгдлийг хэлбэр дүрс, өнгө үзэмж, бүтэц агуулга, мөн чанар зэрэг олон талаас нь ажиглаж өгсөн нэр юм. Ёгт нэр нь хэл зүйн бүтцийн хувьд: нэг үгээс бүтсэн, холбоо үгээс бүтсэн гэж хоёр хуваадаг.

Ёгт нэрийн толь бичигт холбоо үгээс бүтсэн нэр зонхилох бөгөөд холбоо үгийн бүрэлдэхүүнд орсон үгнүүд нэгдэн цогц утга илэрхийлдэг.

Нэмэлт тайлбар зүүлт бүхий толь бичгийг манай ухаант өвөг дээдэс дүймин хэмээн нэрлэдэг байсан юм. Тэгвэл энэ дүймин нь бага нэвтэрхий толийн дайтай болжээ. Төвөд хэлнээс гарал улбаатай “Дүймин” хэмээх нэр уг нь угтаа нэгэн том зохиол бүтээл доторх утга нь ойлгомж муутай хуучирсан үг, ёгт нэр, хатуу бэрх хэллэгийн нэрийн хэлхээс гэсэн утга агуулгатай байсан бол эдүгээ цагт “түүвэр нэр” хэмээх утгыг түүнээс ч өргөн илтгэж байна¹⁰.

1. Бабил - Ловон Бавуу
2. Хачын орны Саран итгэл - Качийн Даваагонбо
3. Аварда - Нуруу бөгтийж, амьсгаадан янцаглах, мэдрэл алдах зэрэг шинж гардаг өвчин
4. Гэдийх дарган - Нурууны үес мурийх өвчин
5. Өрөөл шог - Өрөөл бие унжих
6. Бишазэ - Гарын хурууны ажиллагаа муудах өвчин
7. Кали - Ам, хамар мурийн таталдана
8. Талд хүрсэн - Шар хэмжээнээс хэтэрсэн
9. Гашая - Бие харлах шар
10. Зөгөн - Чийглэг
11. Сэргэр - Нойр замхрах
12. Лэвган - Улаан хэв. Улаан мөртэй тууралт.
13. Ашуд - Энэтхэгт ургадаг нэгэн зүйл жимс
14. Дрэ дрэ хо - Галзуу хижиг

Галзуу өвчин нь хүн болон бусад бүлээн цуст амьтанд хурц хэлбэрийн тархины үрэвсэл үүсгэдэг вирусын гаралтай өвчин юм.

15. Цус хатсан зэлдэ – Хувилз, хувалз - Цус сорж амьдардаг шимэгч хорхой. Нас бие гүйцсэн хачгийг **хувалз** гэнэ. Эмэгчин хувалзын нуруу битүү хуягтай байдаг бол эрэгчин **хувалз** болон авгалдайны нурууны урд хэсэг л хуягтай.

16. Ша ра жа шар - Мөндөр мэт цагаан
17. Сиввү говзэ - Нягт бэржгэр

18. Булчирхай врас - Чихиха
19. Улбарах - Улбагар зөөлөн болох, шалзрах
20. Амруу - Шүлс гоожих
21. Лэвган - Элэг дэлгэрсэн
22. Эзэт - Нян цанх
23. Исгади - Хатгагч
24. Сага – Ялзархай. Ялзарч муудсан юм: ялзархай болсон зүйл (ялзарч муудсан юм). *Ялзархай юм өмхий нь хэцүү, эцэнхий хүн даарах нь хэцүү.*
25. Маразэ-Умайн хорхой. Энэ өвчнийг олон улсын түвшинд “Trichomoniasis” хятадаар 滴虫病 гэж нэрлэнэ. Умайн шилбүүрт хорхой хэмээх нянгаас үүсэх бөгөөд бэлгийн харьцаанаас шууд дамжиж халдана. Энэ шилбүүрт шимүүр хорхой нь гурван янз байна.
 1. Үсний шилбүүрт хорхой,
 2. Амны хөндийн шилбүүрт хорхой,
 3. Умайн шилбүүрт хорхой гэж байдаг.
 Умайн хорхой өвчин нь умайн шилбүүрт хорхойн нян халдварласнаас үүсдэг.
26. Асо - Умайг хөөлгөж, илжрүүлдэг хорхой
27. Рагша - Мангас
Үлгэр домогт гардаг хүн дүрст, санаа муут махчин
28. Бихази – Махчин. Махан идэшт араатан амьтан: **махчин амьтан** (махан идэшт амьтан). Үлгэр домогт гардаг хүний мах иддэг зэрлэг хүн
29. Гүмбади - Цус сорогч
Цус сорж амьдардаг амьтад, босоо ороолон
30. Габзали - Хараал
31. Бидэр - Хүүр босгох гэсэн утгатай
32. Хөрс - Халс
33. Манзир - Нэгэн зүйлийн чулуун эм
34. Халуун өвс – Ман га
35. Цагаан сгэ - Цагаан гаа
36. Байванга - Жиданга
37. Хүнцэл - Гожил
38. Халди – Шар гаа
39. Хорт бор – Давсэн, *IEiscottia Umoides.*

- Давсэн** чигтан Яс хугарсаныг барилдуулна
40. Үдэгүн хошуу - *Sesbania grandiflora L.*
Pers-долоон навчтын үр
 41. Данрог - Бахту
 42. Шраганда – Шүр ханд
 43. Донга - Сондуу буурцаг. Сондуу урт, үр нь хар бөгөөд буурцгийн хонгорцог адил, хонгорцгийг шуламсын сорви гэнэ
 44. Дадриг – Улаалзгана. Red Currant Leaf and Fruits (english); Листья и ягоды смородины красной (русский); *Ribes rubrum (latīna)*
 45. Аглиг - Нарсны шим. Нарсны шим: Намарс, батга, шамбарам /condyloma/, түлэнхий /уухын сацуу угааж шавшина/, хоолой сөөх, буйл, амны хөндийн үрэвсэлд зайлна.
 46. Рэгонба - Улаан үндэс, Улаан үндэс-*Salvia miltiorrhiza Bge*
Рэгон - རྩོན - a bitter medicinal herb, ёгт нэр нь нэгэн хөлт, улаан шим, тагтаан хөл, сарны хор, чулуун улаан, өвст улаан гэдэг.
 47. Хүрэн сүгдам - Хурдан цагаан. Өнгө цагаан, навч хялгасархуу, баширтан цэцгийн нэгэн зүйл цэцэг. **Хялгасан Дэвхэргийн Цагаан (Хурдан Цагаан)**- *Arenaria capillaris Poir.* [*Eremogone capillaris (Poiret.) Fenzl.*]
 48. Гангачүн - Суварган цэцэг. Иш нь богино, салаа ихтэй, навч нь дэвүүр хэлбэртэй цэцэг нь том, хонх хэлбэртэй хөхөвтөр өнгөтэй, гүн бор эрээн судалтай, хонгорцогт жимс нь уртавтар шоролжин хэлбэртэй олон наст өвс.
 49. Хан төмөр - Сороол гонба
 50. Юүмдүүжин – Үрэлж өвс
 51. Барын махан цэцэг - Дагш
 52. Гонтог - Хамбил. Тоонолжин цэцэгтэн-*Brassicaceae Burnett (Cruciferae Juss.)* Тужийн Хамбил- *Draba nemorosa L.*
 53. Хар адон - Арүг
 54. Цагаан дадура – Цагаан танпром

Дүгнэлт

“Мэргэд гарахын орон нэрт төвөд-монгол нэр томъёоны толь”-ийн “Тэжээхүй ухааны аймаг”-аас бэрх болон ёгт 54 үгийг түүвэрлэн авч, үг тус бүрийг орчуулан, тайлбар тайлал хийж, уламжлалт анагаах ухааны онол, эм судлал, эм найрлагын судлалын практикт хэрэглэх боломжийг бүрдүүлснээс гадна, цаашид уламжлалт анагаах ухааны мэдлэгийг ул суурьтай сурч, судлах, уламжлалт анагаах ухааны хичээлийн сургалтын материалд баяжилт хийх, тайлбар хийсэн үгнүүдийг судалгааны эргэлтэд оруулах нөхцлийг хангаж байна.

Номзүй

1. Жанжаа Ролбийдорж. Мэргэд гарахын орон. Үндэстэний хэвлэлийн хороонд хэвлүүлэв. 2002
2. Болд Ш, Цэрэнсодном Д. Монголын уламжлалт анагаах ухааны дээж бичиг. Улаанбаатар, Адмон ХК, 2013, х-7
3. **Ухааны арван орон гэж юу вэ?**. [Эшлэл авсан огноо 2019.04.27]. Мэдээллийн эх үүсвэр: <http://www.budda.mn>
4. Жанжаа Ролбийдорж. Мэргэд гарахын орон. Үндэстэний хэвлэлийн хороонд хэвлүүлэв. 2002
5. Болд Ш, Цэрэнсодном Д. Монголын уламжлалт анагаах ухааны дээж бичиг. Улаанбаатар, Адмон ХК, 2013, х-7
6. Жанжаа Ролбийдорж. Мэргэд гарахын орон. Үндэстэний хэвлэлийн хороонд хэвлүүлэв. 2002
7. Монгол Данжуур. Дэлхийн баримтат өвийн жагсаалтад бүртгэгдсэн өв. [Эшлэл авсан огноо 2019.05.02]. Мэдээллийн эх үүсвэр: <http://www.monheritage.mn>
8. “Мэргэд гарахын орон” толь бичиг ЮНЕСКО-д бүртгэгдлээ. [Эшлэл авсан огноо 2019.05.02]. Мэдээллийн эх үүсвэр: <http://www.ontslokh.mn>

9. Бүрнээ Д, Энхтөр Д. **Төвөд монгол илт өгүүлэх нэрийн толь**. УБ, 2003

10. *Дашдондов Ц.* Монгол-англи шинэ дүймин. [Эшлэл авсан огноо 2019.05.09]. Мэдээллийн эх үүсвэр: [Http://entertainment.mongolnews.mn](http://entertainment.mongolnews.mn)

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
Академич Л.Хүрэлбаатар*